

**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ТЕХНОЛОГИД ТОХИРОХГҮЙ ХҮДРИЙН ОВООЛГЫГ
АШИГЛАХ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДАЛСАН ТАЙЛАН**

2022 он

**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ТЕХНОЛОГИД ТОХИРОХГҮЙ ХҮДРИЙН ОВООЛГЫГ АШИГЛАХ
АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДАЛСАН ТАЙЛАН**

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тандан судалгааны зорилт

Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасанд нийцүүлэн Монгол Улсын төрийн өмч болох “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын **ирээдүйд хэрэглэхээр** бэлтгэсэн хүдрийн овоолгыг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр өгөөжийг иргэдэд хүртээх шийдвэрийн төсөл боловсруулахад судалгааны зорилго оршино.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ирээдүйд ашиглахаар бэлтгэсэн хүдрийн овоолгыг бусад хуулийн этгээд ашиглаж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа нь эрх зүйн зохицуулалтын хүрээнд хэрхэн шийдвэрлэж байгаа нь тодорхойгүй, ил тод, нээлттэй бус буюу сонгон шалгаруулалтгүйгээр хуулийн этгээдэд шилжүүлж, ашиглаж байгаа асуудлыг шийдвэрлэх.

1.Асуудлын мөн чанар, цар хүрээ:

Асуудал үүсч буй шалтгаан, нөхцөл

“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар /цаашид “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ” гэх/-ын ирээдүйд ашиглахаар бэлтгэсэн хүдрийн овоолгыг эрх зүйн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэж байгаа нь тодорхойгүй, ил тод сонгон шалгаруулалтгүйгээр хуулийн этгээдэд шилжүүлж байгаа асуудлыг шийдвэрлэх.

“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газарт дараах 2 төрлийн хүдрийн овоолго байна. Үүнд:

- 1.Тодорхой нөхцөлд үр ашигтай буюу балансын бус хүдрийн овоолго № 8, 9, 2 (Ачит Ихт), 4а (Зэсийн агуулга 0.10%-0.25%)
- 2.Исэлдсэн хүдрийн овоолго. № 10а, 2б, 8а, 12 (Зэсийн захын агуулга 0.25%, исэлдсэн зэсийн исэлдлийн зэрэг 10%-иас дээш)

Хүдрийн овоолгыг ашиглаж ирсэн байдал

1.“Эрдмин” ХХК-ийн төсөл: 1994 оны 03 дугаар сарын 14-ний өдөр “Эрдэнэт” концерн /тухайн үеийн нэрээр/ 51 хувь, “Ар Си Эм” корпораци 49 хувийг эзэмшиж хоёр тал гэрээ байгуулж, “Эрдмин” ХХК-ийг 100.0 мянган ам.долларын дүрмийн сантайгаар үүсгэн байгуулсан. 2001, 2005 онуудад уг компанийн хувьцаа

эзэмшигч болон хувьцааны хувь хэмжээ, компанийн дүрмийн санд тус тус өөрчлөлт орж байсан.

Уурхайн овоолгууд дахь исэлдсэн хүдэр дээр туршилт, судалгааны ажлыг 1994 оноос хойш хийж гүйцэтгэсний дүнд жилдээ **3000 тонн катодын зэс** үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай, Dump Leaching-SX/EW технологи бүхий “Эрдмин” ХХК-ийн туршилтын үйлдвэр баригдаж 1997 онд ашиглалтад орсон.

Үйлдвэрлэлийн түүхий эдийн нөөц: 1995-2011 оны хооронд 14.7 сая.тн исэлдсэн хүдэр, 2.8 сая.тн балансын бус хүдэр нийт 121.5 мян.тн зэс агуулсан 17.5 сая.тн исэлдсэн болон балансын бус хүдрийг “Эрдмин” ХХК-д “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т гэрээгээр нийлүүлсэн.

2.“Ачит-Ихт” ХХК-ийн төсөл: 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Ачит-Ихт” ХХК-нуудын хооронд хамтын ажиллагааны 5/255-10 тоот гэрээ байгуулсан. Тус гэрээний 2.2.3 дахь хэсэгт зааснаар 5-6 сая ам.долларт багтааж, 18-24 сарын дотор **туршилтын үйлдвэр** барих, “Эрдэнэт үйлдвэр” ХХК 34 хувь, “Ачит-Ихт” ХХК 66 хувь эзэмшихээр заасанч **Төслийн компани байгуулж чадаагүй**. Тухайн гэрээ нь Орос-Монголын Зөвлөлөөр батлагдаагүй гэдгийг **“Эрдэнэт үйлдвэрт” ХХК-д хийсэн аудитын дүнэлтэнд дурдсан байна. Мөн 2011 оны 04 сард батлагдсан ТЭЗҮ байхгүйгээр газар шорооны ажил эхэлсэн.**

2013 онд “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Ачит-Ихт” ХХК-нийн хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээнд “Эрдэнэт үйлдвэр” ХХК 34 хувь эзэмших, төслийн гүйцэтгэх удирдлага 10 хувь хүртэл эзэмших, 10 жилийн хугацаанд хүчинтэй байхаар заасан.

2014 онд үйлдвэр ажиллаад 3 жил болсны дараа ТЭЗҮ-ээ батлуулсан.

2014 оны 10 дугаар сарын 10-ны өдөр “Ачит-Ихт” ХХК-нийн Катодын цэвэр зэсийн үйлдвэрийн нээлт болсон.

2015 оны 06 дугаар сарын 26-ны өдөр “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Ачит-Ихт” ХХК-ийн хооронд хамтын ажиллагааны 3 дахь гэрээг байгуулсан. Гэрээнд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 34 хувийг өөрчилж, катодын зэсийг борлуулсан борлуулалтын орлогоос “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д төлөх ашиглалтын төлбөрийн хэмжээ нь 2015 онд 0,5 хувь, 2016 онд 1 хувь, 2017 онд 1,5 хувь, 2018-2034 он дуустал 2 хувь байх, мөн уг гэрээ 20 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна гэж тусгасан. Уг гэрээгээр “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 34 хувь, төслийн гүйцэтгэх удирдлагын 10 хувь эзэмших асуудал байхгүй болсон. Гэрээнд нэмэлт хийж 9-р овоолгыг нэмж өгөхөөр заасан. **152,433 сая.тн хүдэр, зэс 0,189%, металлаар 99264 тн.**

2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр “Ачит-Ихт” ХХК нь “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн зөвшөөрөлгүйгээр “үүсмэл орд”-ын гэрчилгээг холбогдох байгууллагаас авсан.

2018 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас “Ачит-Ихт” ХХК-д хүсэлт хүргүүлэв. Хүсэлтэд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын эзэмших 34 хувийг эзэмших хувьцаатай холбоотой асуудлыг шийдвэрлэсний дараа давуу

эрхийн хувьцаа гаргах асуудлыг шийдвэрлэх зэрэг **асуудлыг тусгасан. /”Ачит-Ихт” ХХК нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хүсэлтийг хүлээж аваагүй./**

3.“Зэс эрдэнийн хувь” ХК-ийн төсөл: “Зэс эрдэнийн хувь” ХК-иас “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ашиглах эрхтэй исэлдсэн хүдрийн овоолгуудыг ашиглан зэсийн үйлдвэр байгуулах саналыг Төрийн өмчийн хороонд 2009 оноос хойш удаа дараа гаргаж, улмаар Төрийн өмчийн хорооноос холбогдох шийдвэрүүд гаргасан ч хэрэгжээгүй.

2013 оны 05 дугаар сарын 02-ны өдөр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, “Зэс эрдэнийн хувь” ХК-ийн хооронд 5/016-13 тоот “Хамтран ажиллах гэрээ”-г 5 жилийн хугацаатайгаар байгуулсан. Уг гэрээнд “Туршилт судалгааны ажлыг гүйцэтгэн, хагас үйлдвэрлэлийн туршилтыг явуулж дууссанаар эдийн засгийн үр ашигтай болох нь тогтоогдвол хүдэр ашиглах, хамтарсан үйлдвэр байгуулах, шинээр байгуулагдах хамтарсан үйлдвэрт “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 34 хувь эзэмших, “Зэс эрдэнийн хувь” ХК исэлдсэн хүдрийн 8а, 12 дугаар овоолгуудаас дээж авах, хагас үйлдвэрлэлийн туршилт судалгааны ажил явуулах, санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлыг бие даан шийдвэрлэхээр” тусгасан.

“Зэс эрдэнийн хувь” ХК 2015 оны 02 сард Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр /BGRIMM-ийн боловсруулсан ТЭЗҮ-г Чин Цэнлүүр ХХК нь орчуулсан оруулж батлуулсан/ батлуулсан тул “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, “Зэс эрдэнийн хувь” ХК-ийн хооронд 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр “Исэлдсэн хүдрийн овоолго ашиглах” №5/277-15 тоот гэрээг 20 жилийн хугацаатайгаар байгуулсан. Энэхүү гэрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын исэлдсэн хүдрийн 8а, 12-р овоолгуудыг “Зэс эрдэнийн хувь” ХК ашиглаж эхэлснээр борлуулалтын орлогоосоо тооцож “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т исэлдсэн хүдрийн овоолго ашигласны төлбөр төлөхөөр заасан байна.

2020 оноос эхлэн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай байгуулсан гэрээний дагуу бүтээн байгуулалтын ажил нь хийгдэж байна.

2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Иргэд	1.“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ашиглах эрхтэй хүдрийн овоолго болон уг хүдрийн овоолгыг шилжүүлэн авсан хуулийн этгээдүүдийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь Орхон аймгийн нутаг дэвсгэрт хэрэгждэг тул уг үйл ажиллагаанаас үүдэн гарах уур амьсгал, байгаль орчны бохирдол зэрэг нөлөөлөлд Орхон аймгийн иргэд өртдөг. 2.“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ашиглах эрхтэй хүдрийн овоолгыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар ажлын байр нэмэгдэх, улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлого нэмэгдсэнээр төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэх зэргээр Монгол Улсын нийт иргэдийн ашиг сонирхол хөндөгдөнө.
2	Хуулийн этгээд	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ашиглаагүй байгаа

		хүдрийн овоолгыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг нээлттэй ил тод байдлаар шийдвэрлэснээр шинээр хуулийн этгээд байгуулж хүдрийг баяжуулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр ажлын байр нэмэгдэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд бусад хуулийн этгээдүүд туслан гүйцэтгэгч хэлбэрээр оролцох зэргээр оролцох боломжтой болно.
3.	Төрийн байгууллага	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ашиглаагүй байгаа хүдрийн овоолгыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар ажлын байр нэмэгдэх, улсын төсвийн орлого нэмэгдэх зэрэг ач холбогдолтой.

ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Зорилго: “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ашиглаагүй байгаа хүдрийн овоолгыг байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, нээлттэй, ил тод, хууль дээдлэх зарчимд нийцүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах шийдвэрийг гаргаж эрх зүйн орчныг бүрдүүлэх.

ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

3.1.Зохицуулалтын хувилбарууд:

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-д заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараахь дүгнэлтийг гаргалаа:

Хувилбар		Судалгааны дүнгийн тухай
1	Тэг хувилбар	Зохицуулалтгүй орхисон тохиолдолд тавьсан зорилгод хүрэх боломжгүй.
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийснээр иргэд, ААНБ-ын идэвх, оролцоо нэмэгдэх магадлалтай боловч тавьсан зорилгод хүрэх боломжгүй.
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Төрөөс зах зээлийн механизмаар дамжуулан зохицуулалт хийх боломжтой ч энэ нь хязгаарлагдмал, тогтвортой байж чадахгүй бөгөөд тавьсан зорилгод хүрэх боломжгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төрөөс санхүүгийн интервенц хийх шаардлагагүй бөгөөд тавьсан зорилгод хүрэх боломжгүй.
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хуулийн этгээдийн оролцоог хангах боломжтой.
6	Захиргааны шийдвэр гаргах	Зорилгод дурдсан асуудлыг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулах боломжгүй.
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, батлуулснаар шийдвэрлэх

Асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл буюу Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах хувилбарыг сонгож байгаа тул Аргачлалын 5.5-д заасны дагуу тандан судлах ажиллагааг үргэлжлүүлж, дараахь зохицуулалтын хувилбарыг дэвшүүлж байна:

Сонгож авсан зохицуулалтын хувилбар:

1.“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын технологид таарахгүй хүдрийн овоолгыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг эрчимжүүлэхийг холбогдох этгээдэд даалгах;

2.Үйлдвэр байгуулахтай холбогдон гарах зардлыг хариуцах, шинээр байгуулах хуулийн этгээдийн хувьцаа эзэмших нөхцөл, компанийн хэлбэрийг заах;

3.Шинээр байгуулах хуулийн этгээдийн хувьцаа эзэмших этгээд болон хувь хэмжээг шийдвэрлэх;

4.Хөрөнгө оруулагчийн хувьцаа эзэмших нөхцөл;

5.Ногдол ашиг хуваарилахад баримтлах зарчим;

6.Шийдвэр гарахаас өмнө хүдрийн овоолгыг ашиглаж байсан хамтарсан хуулийн этгээдүүдийг өөрчлөн зохион байгуулах талаар тусгах.

Зорилгод хүрэх байдал:

Зохицуулалтын хувилбарын эерэг болон сөрөг талыг дараахь байдлаар тодорхойллоо:

Эерэг тал	Сөрөг төл
<p>Монгол Улсын Үндсэн хуульд заасан байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, нээлттэй, ил тод, хууль дээдлэх зарчимд нийцнэ.</p> <p>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ашиглаагүй байгаа хүдрийн овоолгыг ашигласнаар буюу эдийн засгийн эргэлтэд оруулснаар дараах үр ашигтай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хувийн хэвшил, иргэдийн оролцоо хангагдана. - Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас олсон ашиг нийтэд хүртээмжтэй болно. - Ажлын байр нэмэгдэнэ. - Иргэдийн орлого нэмэгдэнэ. - Иргэдийн оролцоо хангагдсанаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дэмжлэг болно. - Туслан гүйцэтгэгчээр ажиллах зэргээр хувийн хэвшлийг дэмжинэ. 	<p>Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нэмэгдэх магадлалтай.</p>

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Тогтоолын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах зардал, үр өгөөж үүснэ:

Зардал	Үр өгөөж
-Зохицуулалтыг нэвтрүүлэхтэй холбоотой ААНБ-ууд, иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэх, таниулж, сурталчилахтай холбоотой зардал гарна.	-Монгол Улсын Үндсэн хуульд заасан байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, нээлттэй, ил тод, хууль дээдлэх зарчимд нийцнэ.
-Төрийн байгууллагын хяналт, шалгалттай холбоотой захиргааны зардал үүснэ.	-Иргэд, хуулийн этгээд хувьцаа эзэмшсэнээр ашиг, орлого нэмэгдэнэ.
-Хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийх, үйлдвэр байгуулахтай холбоотой зардал үүснэ.	-Ажлын байр нэмэгдсэнээр иргэдийн орлого нэмэгдэж, амжиргааны түвшин дээшилнэ.
	-Үйлдвэр байгуулагдсанаар туслан гүйцэтгэгч хуулийн этгээд ажиллах боломжтой болно.
	-Улсын төсвийн орлого нэмэгдэнэ.

ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хувилбар 7-ийн хүрээнд тавигдсан Зорилтын хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг тооцож үзвэл:

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхахтай холбоотой зохицуулалт байхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Төсөл хэрэгжүүлж буй аймгийн иргэдэд давуу байдал үүснэ.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2. Оролцоог хангах			
1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо	Тийм	Үгүй	Холбогдох төрийн болон иргэн, аж ахуйн нэгж	

	оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх			байгууллага зэрэг эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлгүүдтэй мэдээлэл хуваалцаж, оролцоог хангасан.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Бүлгүүдийг тусгайлан тодорхойлсон
1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага				
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчимд нийцүүлснээр хүний эрхийг хангах, хамгаалахад ахиц дэвшил гарна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Төслөөр энэ төрлийн асуудлыг зохицуулахгүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Төслөөр энэ төрлийн асуудлыг зохицуулахгүй.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	<ul style="list-style-type: none"> • Иргэн • Хуулийн этгээд • Төрийн байгууллага
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Энэ төрлийн асуудлыг зохицуулахгүй учир тодорхойлох шаардлагагүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Энэ төрлийн асуудлыг зохицуулахгүй учир тусгах шаардлагагүй.
4.Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төр, иргэн, хуулийн этгээд үүрэг хүлээнэ.
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй..

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Зэсийн үнэ дэлхийн зах зээл дээр буурахаас бусад тохиолдолд хамгаалж чадна.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Төсөлд оролцох хуулийн этгээдэд тодорхой хэмжээнд зардал үүснэ.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөөллийг үзүүлэх боломжтой.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Энэхүү асуудлын хүрээнд хуулийн төсөл батлагдсан тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжид хэрэгжүүлэх шилжилтийн хугацааг урт хугацаатайгаар тусгаж шийдвэрлэх боломжтой.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Тодорхой хэмжээнд мэдээлэх үүрэг үүснэ.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хөндсөн зохицуулалт бий болох эсэх			
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Бүрэн боломжтой.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тодорхой хэмжээнд үйлдвэрлэл нэмэгдсэнээр эерэг нөлөө үзүүлэх боломжтой.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний /гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ажлын байр нэмэгдэх, ногдол ашиг хүртэх зэргээр эерэг үр нөлөө үзүүлэх боломжтой.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ажлын байр нэмэгдэнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжих боломжийг нэмэгдүүлнэ.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Төрд тодорхой зардлын шууд ачаалал үүсгэхгүй, улсын төсвийн татварын орлого нэмэгдэх боломжтой.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.

	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй. Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ажлын байр нэмэгдэнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ажлын байр шинээр бий болж эерэг үр нөлөө үзүүлнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ажлын байр шинээр бий болж эерэг үр нөлөө үзүүлнэ.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Гарах боломжтой гэж үзэж байна.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Эерэг өөрчлөлтүүд гарна.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хяналт тавих зэргээр тодорхой хэмжээнд нөлөөлнө.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хяналт тавих зэргээр тодорхой хэмжээнд нөлөөлнө.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрахад эерэг нөлөө гарна.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Иргэдийн оролцоо, санаачлагыг нэмэгдүүлнэ.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Агаарын бохирдолд нөлөө үзүүлэх боломжтой хэдий ч орлого нэмэгдсэнээр уг сөрөг үр дагаварыг бууруулах боломж

				бүрдэнэ..
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Түлшний хэрэглээ нэмэгдэх боловч төслөөс үүсэх эерэг үр дагавар нь илүү үр ашигтай байх боломжтой.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх боловч төслөөс үүсэх эерэг үр дагавар нь илүү үр ашигтай байх боломжтой.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Агаарын бохирдолд нөлөө үзүүлэх боломжтой хэдий ч төслөөс үүсэх эерэг үр дагавар нь илүү үр ашигтай байх боломжтой.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Усны нөөцөд тодорхой хэмжээнд нөлөөлөл үзүүлнэ.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тодорхой хэмжээнд нөлөөлөл үзүүлнэ.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тодорхой хэмжээнд нөлөөлөл үзүүлнэ.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тодорхой хэмжээнд нөлөөлөл үзүүлнэ.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Тодорхой хэмжээнд үр нөлөө үзүүлнэ.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ ДҮГНЭЛТ ХИЙХ

Энэхүү судалгааны гурав дахь хэсэгт зохицуулалтын хувилбаруудыг тогтоож, эерэг сөрөг талыг харьцуулан судалсан. Үүнээс үзэхэд тэг хувилбар, хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн болон төрөөс санхүүгийн зохицуулалт хийх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх, захиргааны шийдвэр гаргах зэрэг хувилбарууд нь үр ашиггүй тавьсан зорилгыг бүрэн биелүүлэх боломжгүй нь тогтоогдсон.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ашиглаагүй байгаа хүдрийн овоолгыг байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, нээлттэй, ил тод, хууль дээдлэх зарчимд нийцүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах шийдвэрийг гаргаж эрх зүйн орчныг бүрдүүлэх зохицуулалтын хувилбар нь эерэг үр нөлөөтэй, тавьсан зорилгыг зохих хэмжээнд биелүүлэхэд ач холбогдолтой гэж дүгнэж байна.

Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага

1. Ашигт малтмалын газрын тосны газрын архив
2. ТЭЗҮ-нүүд
3. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын архив
4. Үндэсний Аудитын гарзны архив

Хууль тогтоомж

1. ...
2. ...
3. ...